



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 25 өдөр

Дугаар А/205

Булган сум

**“Хүний эрхийн төлөө хамтдаа” нээлттэй өдөр
зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны хуралдааны III/03 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны А/32 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын дарга, аймгийн Засаг дарга нарын хамтран баталсан удирдамжийн дагуу “Хүний эрхийн төлөө хамтдаа” нээлттэй өдөр арга хэмжээг 2024 оны 10 дугаар сарын 28, 29-ний өдрүүдэд Булган аймагт зохион байгуулсугай.

2 Хүний эрхийн төлөө хамтдаа” нээлттэй өдөр арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 3,000,000 (Гурван сая) төгрөгийг “Бүх нийтийн эрх зүйн боловсрол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

3. Хүний эрхийн төлөө хамтдаа” нээлттэй өдөр арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулан ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ